



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
САЛБАРЫН УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ДААЛГАВАР

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 07/00-00/001-05

Улаанбаатар хот

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал,
эрүүл ахуйг хангаж ажиллах тухай

Сүүлийн жилүүдэд хөдөлмөр эрхэлж байгаа иргэд ажил үүргээ гүйцэтгэх явцдаа үйлдвэрлэлийн осолд өртөн бэртэж гэмтэх, амь насаа алдах тохиолдлууд олноор гарч, 2023 онд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт нийт 103 үйлдвэрлэлийн осол, хурц хордлого бүртгэгдсэнээс 36 хүн хөнгөн, 54 хүн хүнд, 13 хүн амь насаа алдсан харамсалтай тоо мэдээ байна.

Иймд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын ажилтнуудын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгоход ажлын байранд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үр нөлөө бүхий удирдлагын тогтолцоо /менежмент/-г нэвтрүүлэх шаардлагатай байна.

Үүнтэй уялдуулан ажил олгогч Та бүхэнд хандан ажилтан хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах үүднээс Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, журам, стандартын шаардлагыг ханган ажиллахыг ДААЛГАЖ байна.

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль, тогтоомж, үндэсний стандарт, түүнтэй холбогдуулан гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг мөрдөж ажиллах;

2. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журам, холбогдох эрх зүйн бичиг, баримтыг шинэчлэн боловсруулж мөрдөх;

3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 2023-2025 оны хамтын хэлэлцээрээр тохиролцсон хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, хөдөлмөр зохион байгуулалт, цалин хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажиллах;

4. Ажлын байранд ажил үүргээ гүйцэтгэх явцад тохиолдож болох аюулыг тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийж, учирч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах;

5. "Аюул, ослоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөө" боловсруулж энэхүү төлөвлөгөөнд эрүүл, аюулгүй ажлын байрыг бий болгох, ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, тохиолдож болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангах, ажлын үе шат бүрт авах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

6. Ажилтанд зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх сургалтыг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулж, нийт ажилтныг хамруулах;

7. Эрсдэлтэй ажлын байранд ажилладаг ажилтныг эрсдэлтэй ажлын байрны болон тусгай (химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг,

1511190018

биологийн идэвхт бодис, түүний нөлөөлөл) сургалтад хамруулан, өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх мэдлэг, чадвар, дадлагыг эзэмшүүлэх;

8. Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны 3 шатны зааварчилгааг ажил үүргийн онцлогт нийцүүлэн тухайн асуудал хариуцсан инженер техникийн ажилтан, удирдах албан тушаалтан тогтмол өгч хэвших, хяналт тавих;

9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хуульд заасан хэмжээнд төлөвлөн зарцуулж хэвших;

10. Байгууллагын түвшинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн алба, ажилтныг хууль тогтоомжид заасан бүтэц орон тоогоор ажиллуулах, мэргэшүүлэх;

11. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарах бүрт Засгийн газраас тогтоосон дүрмийн дагуу осол, хурц хордлогыг судлан бүртгэж, шалтгааныг тогтоон дахин уг шалтгаанаар осол гаргуулахгүй байх талаар бодитой арга хэмжээг төлөвлөж ажиллах;

12. Хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээгээр ажил, үүрэг гүйцэтгэгч, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, хоршоо, нөхөрлөлийн гишүүн хөдөлмөр эрхлэх явцад үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулсан (Засаг даргын Тамгын газраас нэг, ажил олгогч болон ажилтны төлөөллөөс тус бүр хоёр хүний бүрэлдэхүүнтэй) комисс тухайн гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх;

13. Ажилтныг олон улсын стандарт, шаардлагад нийцсэн чанарын баталгаа бүхий ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжөөр хангах, зориулалтын дагуу бүрэн хэрэглэж хэвшүүлэх, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн эдэлгээний хугацааг судалгаанд үндэслэн, нэр, төрөл жагсаалтыг баталж мөрдүүлэх;

14. Машин механизм, тоног төхөөрөмжийг суурилуулах, их засварын дараа ашиглалтад оруулахдаа хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчаар хянуулж, гэрчилгээ авсан байх;

15. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт бүртгэгдсэн үйлдвэрлэлийн ослын 49 хувь нь тоног төхөөрөмж болон эд зүйлд хавчуулагдсан шалтгаанаас үүсэж байгаа тул үйлдвэрлэлийн зориулалттай, хүний эрүүл мэндэд аюул учруулж болох машин механизм, тоног төхөөрөмжийн бүтэц, хийц, хөдөлгөөнт хэсэг, удирдлага, дохиоллын систем, бүрдэл хэсгийн (ажлын байр, гарц, шат, хашлага, хамгаалах хэрэгсэл) аюулгүй ажиллагааны шаардлагыг хангуулах;

16. Цахилгааны тоног төхөөрөмж болон даралтат сав нь зураг төслийн дагуу угсрагдсан, газардуулгатай, газардуулгын даацын баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн, цахилгаан ашиглалтын аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангасан, удирдлага, дохиолол, хаалт, хамгаалалттай, гарч болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх хэрэгслээр тоноглогдсон байх;

17. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт ажилтныг тогтмол хамруулж, ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг зохион байгуулах;

18. Ажил олгогч ажлын байранд эргономикийн хүчин зүйл, дуу шуугиан, доргион, химийн бодисын ууршилт, эрдсийн тоосноос ажилтны эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлийг үнэлэх, түүний нөлөөллийг бууруулж, ажилтны эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэн, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

19. Ажилтны ахуйн байр /хувцас солих, амрах, хооллох, усанд орох, гар угаах, бие засах газар, хувцас угаалгын газар/-ыг эрүүл ахуйн стандарт шаардлагын дагуу төлөвлөж,

цэвэрлэгээ ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж хэвших, ажилтны тооноос хамааруулан шүршүүр, суултуур, угаагуурын тоог нэмэгдүүлэх, ажлын байранд ундны цэвэр ус, түр амрах байраар хангах, гэмтэл, бэртэл тохиолдох үед үзүүлэх анхан шатны тусламжийн бэлэн байдлыг хангуулах;

20. Ажилтныг илчлэг, чанар сайтай, амин дэмээр баялаг хоол хүнсээр хангах замаар ажилтны эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд дэмжиж ажиллах;

21. Инженер техникийн ажилтан, үйлдвэрийн ажилтнуудад эрүүл мэндийн боловсрол олгох, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

22. Эрсдэлийн түвшин их ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд тухайн ажилтны 36 ба түүнээс дээш сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээгээр заавал даатгуулах;

23. Аж ахуйн нэгж, байгууллагын газар, хэлтэс, нэгжийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаанд дотоод хяналтын тогтолцоог нэвтрүүлж, техникийн бүрэн бүтэн байдал, хэвийн үйл ажиллагааг хангах замаар үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Энэхүү албан даалгаврыг аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч бүр хэрэгжүүлэн, биелэлтийг үйл ажиллагаа эрхэлж буй нутаг дэвсгэрт хамаарах аймаг, дүүргийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 2024 оны 10 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэн, орон нутгийн зөвлөл нь албан даалгаврын биелэлтийг зөвлөлийн хурлаар хэлэлцэн, цаашид хэрэгжүүлэх зөвлөмж, шийдвэр гаргаж ажиллахыг даалгаж байна.

САЛБАРЫН УЛСЫН
ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ



Б.НАРАНГАРАВ

Боловсруулсан:
Хүндэтгэсэн:
Хүндэтгэсэн: